

Хятад улсын элчин сайдын яам
Herrn Wu Ken

Märkisches Ufer 54
10179 Berlin

Эрхэм хүндэт элчин сайд танаа,

Өвөр Монголын өөртөө засах орны Монгол сургуулиуд хүүхдүүдээ эх хэл дээр нь сургаж хүмүүжүүлдэг байсныг өөрчилж байгаа тухай мэдээг бид ихэд цочирдон хүлээж авлаа.

Энэхүү өөрчлөлтийг эсэргүүцэж хэд хэдэн хүмүүс амь насаа егүүтгэжээ.

Монгол сургуулиудын сургалт Монгол хэл дээр хичээллэдэг байсныг хэвээр нь үлдээхийн төлөө тэмцсэн эцэг эхчүүдийг баривчлан хорьж, ял шийтгэл оноожээ. Монгол хэл дээрх сурах бичгүүдийг ч мөн хориглосон байна.

Мөн албаны баримт бичгүүд дээр зөвхөн хятад хэл л иргэншлийн хэл мэтээр цохон тэмдэглэсэн нь шовинист үзэл санааг агуулжээ.

Хятад улс бол НҮБ-ийн түгээмэл тунхагт нэгдсэн улс билээ.

НҮБ-ийн түгээмэл тунхагт тусгаснаар үндэсний цөөнхийн ялангуяа сурах, боловсрох эрх болон захиргааны ба шүүхийн үйл ажиллагаа эх хэлээр нь явагдахыг чухалчилдаг.

Европын улсуудад эдгээр эрхүүдийг машид эрхэмлэдэг. Европын холбооны ард иргэдийн 10% орчим үндэсний цөөнхөд тооцогддог. 2018 онд Европын холбооноос үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах наад захын стандартыг боловсруулсан тогтоол гаргасан. Энэ бол Европын үндэсний цөөнхийн асуудал болох, тэдний эх хэлний хэрэглээ, соёл уламжлалаа хөгжүүлэх боломж нь засаг, захиргааны үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй гэсэн тогтоол юм.

Өвөр монголын хүүхдүүдийн хувьд дээр дурдсан наад захын стандарт эрх хангагдаагүй байна гэж бид үзэж байгаа тул бидний эсэргүүцлийг Хятад улсын төрийн байгууллагад дамжуулан хүргэхийг хүсье.

Улс орны дотоод эв нэгдлийг захиргаадлын хүчээр бүтээх боломжгүй юм.

Хүндэтгэсэн